



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/113/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улиастай сум 2024 он</p>	<p>Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа Утас: 99993365 Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn Аудитын менежер: Х.Болдбаатар Утас: 99105506 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Оюунсүвд Утас: 99076038 Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хая

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улаанбаатар, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

Ауд 4.03.18 № 447

танай _____ -ны № _____ -т

СОНГИНО СУМЫН
ЗАСАГ ДАРГА А.ХАНДМАА-д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Сонгино сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сонгино сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

2023 оны санхүүжилтийг өмнөх онтой харьцуулахад 718,319.6 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь татвар болон татварын бус орлого 323,612.9 мянган төгрөгөөр буурч, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 137,732.8 мянган төгрөгөөр, тус онд цалин нэмэгдсэнтэй холбогдуулан орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 217,873.4 мянган төгрөгөөр, татварын орлогын санхүүжилт 318,211.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн, улсын төсөвт байгууллагын тогтмол зардал 337,829.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс олгосон, төвлөрүүлэх шилжүүлэг 30,285.1 мянган төгрөгөөр өссөн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын гол асуудал

Сонгино сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар дээд шатны төсвийн захирагчаас тодотгосон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн дэмжлэг болон Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтэд тодотгол хийгээгүй 104,947.1 мянган төгрөгийн зөрчил байна.

Аудит(D)A4-160т/2024

Бусад асуудлын хэсэг

Сонгино сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 281,908.2 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 619,653.7 мянган төгрөг буюу 119.8 хувиар давсан байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 11,329.3 мянган төгрөгийг 20 иргэнд буцаан олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		1,093,199.4	969,705.6
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	892,560.5	669,809.6
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	89,432.4	130,734.4
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	111,206.5	169,161.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		686,043.0	967,563.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	686,043.0	967,563.8
39200	Биет хөрөнгө		673,836.0	952,701.8
39300	Биет бус хөрөнгө	13	12,207.0	14,862.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,779,242.4	1,937,269.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		9,488.2	9,488.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	9,488.2	9,488.2
41300	Өглөг	17а, 17б	9,488.2	9,488.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,769,754.2	1,927,781.1
51	Засгийн газрын хувь оролцоо		1,769,754.2	1,927,781.1
51100	Засгийн газрын оруулсан капитал		390,906.3	390,906.3
51200	Хуримтлагдсан үр дүн		1,093,814.1	1,251,841.0
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		285,033.9	285,033.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,779,242.4	1,937,269.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		2,468,908.6	1,966,854.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО		877,065.3	527,000.8
110	Орлогын албан татвар		150,971.7	303,385.9
1100	Хувь хүний орлогын албан татвар		162,296.1	314,715.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-11,324.4	-11,329.3
113	Хөрөнгийн албан татвар		51,560.2	18,562.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж		674,533.4	205,052.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	462,889.4	434,651.5
120	Нийтлэг татварын бус орлого		462,889.4	434,651.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		1,128,953.9	1,005,201.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	1,528,341.1	1,358,203.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,528,341.1	1,358,203.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		550,902.4	1,165,380.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		218,768.1	401,879.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		30,347.7	46,731.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		69,740.9	67,988.2
2104	Хангамж, бараа материалын зардал		39,650.3	61,701.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		9,950.5	1,010.0
2107	Томилолт, зочны зардал		8,806.0	7,831.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,559.4	2,104.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		166,079.5	576,134.7

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		977,438.7	192,822.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		940,567.5	608,650.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН		3,630,462.4	450,623.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		-2,689,894.9	158,026.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,523,878.5	4,523,878.5
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,769,754.2	1,769,754.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,459,649.1	4,459,649.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-64,229.4	-64,229.4
9	Тайлант үеийн үр дүн	-2,689,894.9	-2,689,894.9
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,769,754.2	1,769,754.2
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,927,781.1	1,927,781.1
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,769,754.2	1,769,754.2
19	Тайлант үеийн үр дүн	158,026.9	158,026.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,089,939.2	1,640,691.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	877,065.3	527,000.8
110	Орлогын албан татвар	150,971.7	303,385.9
1100	Хувь хүний орлогын албан татвар	162,296.1	314,715.1
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-11,324.4	-11,329.3
113	Хөрөнгийн албан татвар	51,560.2	18,562.5
118	Бусад татвар, төлбөр, хураамж	674,533.4	205,052.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	2,370.4	1,170.6
1181	Газрын төлбөр	1,189.5	11,317.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	670,973.6	192,564.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	83,920.0	108,488.7
120	Нийтлэг татварын бус орлого	83,920.0	108,488.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,128,953.9	1,005,201.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,426,757.7	1,260,525.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,426,757.7	1,260,525.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	449,221.5	1,067,702.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	218,888.1	401,778.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,347.7	46,731.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,857.7	67,988.2
2104	Хангамж, бараа материалын зардал	15,528.7	18,926.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,092.0	1,200.0
2107	Томилолт, зочны зардал	3,786.0	6,005.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,356.8	3,492.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	92,364.6	521,579.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	977,536.2	192,822.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	663,181.4	380,166.3
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	500,166.5	534,425.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	500,166.5	534,425.8
2200	Дотоод эх үүсвэрээр	500,166.5	534,425.8
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-500,166.5	-534,425.8

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-100.0	-68,491.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	100.0	68,491.4
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	162,914.9	-222,750.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	729,645.6	892,560.5
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	892,560.5	669,809.6

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,864,508.1	1,660,510.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,205,020.8	1,143,280.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,182,542.2	1,120,802.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	421,884.7	397,759.8
210101	Үндсэн цалин	309,844.4	269,464.0
210102	Нэмэгдэл	101,185.6	94,658.2
210104	Урамшуулал	10,854.7	33,637.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,735.5	46,731.4
210201	Тэтгэврийн даатгал	35,860.1	31,866.9
210202	Тэтгэмжийн даатгал	4,218.8	3,748.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,375.0	3,015.6
210204	Ажилгүйдлийн даатгал	843.8	747.4
210205	Эрүүл мэндийн даатгал	8,437.8	7,353.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	395,818.3	385,276.1
210301	Гэрэл, цахилгаан	29,511.0	22,477.1
210302	Түлш, халаалт	362,892.4	360,424.0
210303	Цэвэр, бохир ус	3,414.9	2,375.0
2104	Хангамж, бараа материалын зардал	18,437.4	18,427.1
210401	Бичиг хэрэг	3,321.3	3,312.2
210402	Тээвэр, шатахуун	12,148.3	12,148.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,967.8	2,966.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,701.0	15,680.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,500.0	4,500.0
210604	Урсгал засвар	11,201.0	11,180.5
2107	Томилолт, зочны зардал	5,349.6	5,285.3
210702	Дотоод албан томилолт	5,349.6	5,285.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,794.6	3,492.4
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,160.0	2,719.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	710.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	469.1	333.6
210804	Тээврийн хэрэгслийн татвар	227.7	227.7
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73.8	73.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	0.0
210807	Газрын төлбөр	138.3	138.3
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.7	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	267,821.1	248,149.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	265,277.7	245,731.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,543.4	2,418.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	22,478.6	22,478.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,478.6	22,478.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	498,067.3	448,738.8
223001	Бусад хөрөнгө	498,067.3	448,738.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	161,420.0	68,491.4

230001	Эргэж төлөгдөх зээл	161,420.0	68,491.4
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,864,508.1	1,670,891.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,234,611.0	1,644,293.5
320001	Орон нутгийн төсвөөс	1,005,248.1	1,414,930.7
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	229,362.9	229,362.8
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	629,897.1	26,597.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	26,597.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	629,897.1	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	124,541.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	134,921.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	42,370.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,370.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,587.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,019.0
210101	Үндсэн цалин	4,019.0
2104	Хангамж, бараа материалын зардал	499.5
210402	Тээвэр, шатахуун	499.5
2107	Томилолт, зочны зардал	720.0
210702	Дотоод албан томилолт	720.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,348.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,348.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,782.7
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,782.7
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	9,782.7
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	42,370.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	42,370.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	42,370.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сонгино сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Төрийн үйлчилгээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, үндсэн үүргээ мөрдлөг болгон, УИХ, Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөр, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, хэлтэс агентлагуудаас гаргасан тогтоол шийдвэр, заавар журам, албан даалгаврыг хэрэгжүүлэх, сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хийж хэрэгжүүлэхээр зорилтуудыг биелүүлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 79 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 85.4 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сонгино сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сонгино сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 158,026.9 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	892,560.5	669,809.6	(222,750.9)
Авлага	89,432.4	130,734.4	41,302.0
Бараа материал	111,206.5	169,161.5	57,955.0
Үндсэн хөрөнгө	686,043.0	967,563.8	281,520.8
Нийт хөрөнгө	1,779,242.4	1,937,269.3	158,026.9
Өр төлбөр	9,488.2	9,488.2	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,769,754.2	1,927,781.1	158,026.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,779,242.4	1,937,269.3	158,026.9

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 669,809.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 222,750.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	892,560.5	669,809.6	(222,750.9)
Дүн	892,560.5	669,809.6	(222,750.9)

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 222,750.9 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны татварын давсан орлогоос байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд төсөв баталж зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 130,734.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 41,302.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	120.0	19.4	(100.4)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	89,312.4	130,715.0	41,402.6
Дүн	89,432.4	130,734.4	41,302.0

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 41,302.0 мянган төгрөгөөр өссөн нь ажиллагсадтай холбоотой авлага 100.4 мянган төгрөгөөр буурсан, Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага 41,402.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Сумын Хоршоо хөгжүүлэх сангийн 24,820.0 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл, оршин суугаа хаяг нь тодорхойгүй зээлдэгч нарын 17,854.0 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг барагдуулахаар, эрэн сурвалжлуулахаар шүүхэд хандаагүй зөрчилд албан шаардлага өгсөн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 169,161.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 57,954.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Хангамжийн материал			
Бичиг хэргийн материал	1,233.2	1,569.1	335.9
Аж ахуйн материал	1,644.0	1,913.4	269.4
Түлш, шатах тослох материал			0.0
Барилгын засварын материал		90.0	90.0
Хүнсний материал			0.0
Бусад хангамжийн материал	94,719.3	150,978.9	56,259.6
Мал амьтад	13,610.0	14,610.0	1,000.0
Дүн	111,206.5	169,161.4	57,954.0

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 57,95.0 мянган төгрөгөөр өссөн нь Хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй ирсэн 3,556.2 мянган төгрөгийн хүлэмжийг данс бүртгэлд тусгасан, малын нас дэвшил хийж, 18,260.0 мянган төгрөгийг хасаж, 19,260.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, тайлант онд 191,400.5 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 130,203.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан, зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь бараа материалыг зөв ангилж бүртгээгүй, малын нас дэвшилтийг буруу хийж бүртгэсэн 100,877.0 мянган төгрөгийн алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 967,563.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 282,520.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	673,836.0	952,701.8	278,865.8
Барилга, байгууламж, орон сууц	473,756.3	473,756.3	0.0
Авто-тээврийн хэрэгсэл	137,915.0	147,000.0	9,085.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	172,735.6	394,435.6	221,700.0
Тавилга, аж ахуйн эд хогшил	45,818.6	35,689.6	-10,129.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	381,082.8	549,426.8	168,344.0
Бусад үндсэн хөрөнгө			0.0
Ном	1,003.9		-1,003.9
Биет бус хөрөнгө	11,627.0	14,522.0	2,895.0
Программ хангамж	3,850.0	8,350.0	4,500.0
Бусад биет бус хөрөнгө	10,262.0	10,262.0	0.0
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(524,250.1)	(542,221.3)	-17,971.2
Дүн	686,043.0	967,563.8	282,520.8

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 282,520.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 85,687.0 мянган төгрөгөөр хөрөнгө худалдаж авч, сумын ОНХС-ийн хөрөнгөөр 130,244.5 мянган төгрөгийн хөрөнгө, Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 199,700.0 мянган шатаах зуух үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 13,861.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж, тайлант оны элэгдлийн зардалд 129,948.0 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь тайлант оны элэгдлийн зардлыг дутуу тооцоолсон 3,846.9 мянган төгрөгийн алдаа илэрсэнд залруулга хийсэн байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 9,488.2 мянган төгрөг байна.

Хүснэгт 6. Өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Байгууллагад төлөх өглөг	9,488.2	9,488.2	0.0
Дүн	9,488.2	9,488.2	0.0

Дээрх өр төлбөр нь сумын ЗДТГ-ын халаалтын өглөг байна. 2020 онд үүссэн тус өглөгийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах талаар албан шаардлага өгсөн боловч тайлант онд хэрэгжээгүй, аудитын явцад тус өглөгийг төлж барагдуулсан байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,927,781.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 158,026.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	390,906.3	390,906.3	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	390,906.3	390,906.3	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	-	-	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,093,814.1	1,251,841.0	158,026.9
Өмнөх үеийн үр дүн	3,783,709.0	1,093,814.1	-2,689,894.9
Тайлант үеийн үр дүн	(2,689,894.9)	158,026.9	2,847,921.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	285,033.9	285,033.9	0.0
Дүн	1,769,754.3	1,927,781.2	158,026.9

Эх сурвалж: Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 158,026.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,842,826.4 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,407,859.7 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 297,255.3 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 184,135.3 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, 434,966.7 мянган төгрөгийн Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс, 259,572.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 161,420.0 мянган төгрөгийг Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс, 505,477.1 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 99,184.0 мянган төгрөгөө, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 45,227.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс Улсын төсөвт байгууллагуудад олгох тогтмол зардлыг нэмэгдүүлж баталсан боловч сум төсөвт тодотгол хийгээгүй байна.

Аудитын илрүүлэлт: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн дэмжлэг болон Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтэд тодотгол хийгээгүй 104,947.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэлээ.

Аймгийн төсвийн тодотголд үндэслэн тус сумын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тооцоолоход 1,864,508.1 мянган төгрөг байна.

Гүйцэтгэлээр санхүүгийн дэмжлэгээс 395,639.3 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 229,362.8 мянган төгрөгийн, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 337,829.8 мянган төгрөгийн, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 26,567.5 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 270,978.5 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 410,513.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 193,617.1 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 800.5 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, Хоршоо хөгжүүлэх сангийн

зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	396,439.8	395,639.3	800.5
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	229,362.8	229,362.8	0.0
3	Татварын болон татварын бус орлого	270,978.6	270,978.6	0.0
4	Урьд оны үлдэгдэл	629,897.1	410,513.0	219,384.1
5	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	26,567.5	(26,567.5)
6	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	337,829.8	337,829.8	0.0
ДҮН		1,864,508.1	1,670,891.0	193,617.1

Татварын болон татварын бус орлогоор 619,653.7 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 11,329.3 мянган төгрөгийг, санхүүжилтэд 269,908.2 мянган төгрөгийг олгож, давж биелсэн 338,416.2 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд байршуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,660,510.9 мянган төгрөг буюу 89.1 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бараа үйлчилгээний бусад зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ИТХ, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

<i>/мянган төгрөгөөр/</i>					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	101,287.1	96,333.2	4,953.9	95.1%
2	Засаг даргын Тамгын газар	765,903.9	719,679.1	46,224.8	93.9%
3	Орон нутгийн хөгжлийн сан	498,067.3	448,738.8	49,328.5	90.1%
4	Хоршоо хөгжүүлэх сан	161,420.0	26,597.5	92,928.6	42.4%
5	Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал	337,829.8	327,268.4	10,561.4	96.9%
ДҮН		1,864,508.1	1,660,510.9	228,494.1	89.1%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

2023 онд нэмэлт санхүүжилтээр 42,370.1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 32,587.4 мянган төгрөгийг цалин, тээвэр шатахуун, дотоод албан томилт, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулж, 9,782.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу

Сонгино сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сонгино сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 1/13 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,525,770.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 37,886.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28,414.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Сонгино сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага өгөгдөөгүй, дотоод хяналттай холбоотой 87,121.5 мянган төгрөгийн зөрчилд аймгийн Засаг даргад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн боловч хугацаандаа хэрэгжээгүй тул дараагийн шатны төсөв захирагчид шилжүүлэхээр шийдвэрлэлээ.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Хариуцлага тооцох албан шаардлага	1	87,121.5	-	-	0%
Нийт дүн	1	87,121.5	-	-	0%

/мянган төгрөгөөр/

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой 104,947.1 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 104,947.1 мянган төгрөгийн зөрчил нь шинж чанарын хувьд материаллаг тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсөв баталсан болон тодотгосон тогтоолыг Төсвийн шууд захирагчдад олгосон санхүүжилттэй тулгахад дээд шатны төсвийн захирагчаас тодотгосон Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн дэмжлэг болон Хүүхдийн цэцэрлэг, Эрүүл мэндийн төвийн тогтмол зардлын санхүүжилтэд тодотгол хийгээгүй 104,947.1 мянган төгрөгийн зөрчил байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-д "Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ", 34.2.1-д "дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй шаардлага бий болсон" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дээд шатны төсвийн захирагчаас тодотгосон төсвийг сумын ИТХ-аар нэмж тодотгож байх;

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
ИТХ, ЗДТГ-ын санхүүгийн дэмжлэг болон Хүүхдийн цэцэрлэг, ЭМТ-ийн тогтмол зардлын санхүүжилтэд тодотгол хийгээгүй	1	104,947.1					1	104,947.1				
Дүн		104,947.1						104,947.1				

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

Ц.ОЮУНСУВД



Огноо: 2024-03-25